



НИЙСЛЭЛИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ТӨЛӨӨЛӨГЧ

Жанжин Д.Сүхбаатарын талбай 7, 1 дүгээр хороо,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160-0035  
Утас: (976-11) 325826  
Цахим хуудас: [www.citycouncil.mn](http://www.citycouncil.mn)

2022.04.04 № 04/172

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА  
Ж.БАТБАЯСГАЛАН ТАНАА

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2021 оны 62 дугаар тогтоолор  
байгуулагдсан “Үндэсний соёл амралтын хүрээлэн”  
ХХК-ийн талаар судалж, цаашид авч хэрэгжүүлэх  
арга хэмжээний санал боловсруулах чиг үүрэг  
бүхий ажлын хэсгийн санал дүгнэлтийг тогтоолын  
төслийн хамт өргөн мэдүүлж байна.

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн  
Хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Хавсралт....хуудас



## НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ

“ҮНДЭСНИЙ СОЁЛ АМРАЛТЫН ХҮРЭЭЛЭН” ХХК-ИЙН ТАЛААР СУДАЛЖ, САНАЛ  
ДҮГНЭЛТ БОЛОВСРУУЛАХ ҮҮРЭГ БҮХИЙ АЖЛЫН ХЭСГИЙН  
НЭГДСЭН САНАЛ, ДҮГНЭЛТ

# **НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН 2021 ОНЫ 62 ДУГААР ТОГТООЛООР БАЙГУУЛАГДСАН АЖЛЫН ХЭСГИЙН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2022.03.18-ны өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 62 дугаар тогтоолоор “Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах Үндэсний соёл амралтын хүрээлэнгийн газар, түүний олголт, төлөвлөлтийн талаар судалж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий” ажлын ажлын хэсэг Нийслэлийн ИТХ-ын Төлөөлөгч, Засаглал, эрх зүйн шинэтгэлийн хорооны дарга Б.Мягмираар ахлуулан тухайн үеийн Нийслэлийн ИТХ-ын Тэргүүлэгч Д.Гантулга, Д.Энхтуяа, М.Халиунбат, Төлөөлөгч Н.Батсүмбэрэл, П.Наранбаяр, Н.Баярчимэг, ИТХ-ын даргын зөвлөх Ш.Үнэнбат, Ерөнхий архитектор бөгөөд Хот байгуулалт, хөгжлийн газрын дарга Ц.Тулга, Газар зохион байгуулалтын албаны дарга А.Энхманлай, Өмчийн ашиглалт, удирдлагын газрын дарга М.Баяраа, ИТХ-ын Ажлын албаны Хууль эрх зүй, хяналт үнэлгээний хэлтсийн дарга А.Анхбаяр, Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Б.Мөнгөншагай нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулагдан ажиллалаа.

Ажлын хэсэг байгуулагдсанаас хойш нийт 4 удаа хуралдаж “Үндэсний соёл амралтын хүрээлэн” ХХК-ийн нөхцөл байдалтай газар дээр нь очиж танилцсан, дараах чиглэлээр мэдээллийг судалж, холбогдох мэргэжлийн байгууллагуудын танилцуулгыг сонсож ажиллалаа. Үүнд:

1. “Үндэсний соёл амралтын хүрээлэн” ХХК-ийн эзэмшиж байгаа болон түүний ойр орчмын газрын олголт.
2. “Үндэсний соёл амралтын хүрээлэн” ХХК-ийн эзэмшиж буй газрын ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө.
3. “Үндэсний соёл амралтын хүрээлэн” ХХК-ийн өнөөгийн нөхцөл байдлын талаар.
4. “Үндэсний соёл амралтын хүрээлэн” ХХК-ийн өмнө нь хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ, цаашид хэрэгжүүлэхээр төлөвлөж буй “Villa” төслийн талаар.
5. “Үндэсний соёл амралтын хүрээлэн” ХХК-ийн санхүүгийн 2015-2020 оны тайлан болон хөрөнгө оруулалтын мэдээлэл.
6. Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрыг татан буулгах, хамтарсан аж ахуйн нэгж байгуулах үйл ажиллагаа болон газар олголтын талаар судалж, ажлын хэсгийн санал дүгнэлтийг боловсрууллаа.

## **1. “Үндэсний соёл амралтын хүрээлэн” ХХК-ийн талаар**

### **Товч түүх**

Үндэсний соёл амралтын хүрээлэн нь анх тухайн үеийн МАХН-ын Төв Хорооны 1965 оны 333 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын хүүхэд залуучуудын дунд улс төр, соёл хүмүүжлийн ажил өргөн зохиож, тэдний чөлөөт цагийг зөв

боловсон өнгөрөөж байх зорилгоор анх “Хотын Соёл амралтын парк” нэرتэйгээр байгуулагдсан.

Анх байгуулагдахаа 37 га газартай, 6 мянган мод бут, 60 гаруй мянган м2 зүлэгжүүлсэн талбайтай, 20 гаруй барилга байгууламж, 14 төрлийн ил тоглоом, 3000 хүний суудалтай цэнгэлдэх хүрээлэн, зуны театр, бүжгийн талбай, нэг удаа 300 хүнд үйлчлэх зоогийн газар, цэцгийн хүлэмж, засварын байр, конторын барилга, 30 гаруй жижиг тоглоомын барилга байгууламжтай байсан бөгөөд аж ахуйн тооцоон дээр үндэслэн өөрөө өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар үйлдвэрийн газрын статустай ажиллаж байсан.

### **Хамтарсан компани байгуулсан тухай**

Нийслэлийн Засаг дарга 2004 оны 562 дугаар захирамжаар Монгол улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2004 оны 1162 тоот албан бичгийн үндэслэн, Япон Улсын Иточу корпорацаас боловсруулсан төслийг дэмжиж “Үндэсний соёл амралтын хүрээлэн” НӨҮГ-т хөрөнгө оруулалт хийхийг тус корпорацын Улаанбаатар дахь төлөөлөгчийн газарт зөвшөөрсөн байна. Улмаар Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2005 оны “Хамтарсан компани байгуулах тухай” 188 дугаар тогтоолоор Үндэсний соёл амралтын хүрээлэнг орчин үеийн шаардлага, олон нийтийн хэрэгцээ, дэлхий нийтийн жишигт нийцүүлэн сайжруулах зорилгоор “Иточу” корпорацаас боловсруулсан төслийг дэмжиж, Улаанбаатар хот - Япон Улсын “Иточу” корпорацын хамтарсан хөрөнгө оруулалттай компани байгуулахыг зөвшөөрч, “Үндэсний соёл амралтын хүрээлэн” НӨҮГ-г 2005 оны 10 дугаар сарын 01-ний өдөр татан буулгасан байна.

Монгол улсын Гадаадын хөрөнгө оруулалт гадаад худалдааны агентлагийн даргын 2005 оны А/2770 дугаар тушаалаар Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Япон Улсын хуулийн этгээд болох “Иточу” корпорацын хооронд 2005 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр байгуулсан гэрээ, дүрмийн дагуу тоглоомын төв, соёл, урлаг, амралтын цогцолбор ажиллуулах, гадаад, дотоод худалдаа эрхлэх Монгол-Японы хамтарсан хөрөнгө оруулалттай “Үндэсний соёл амралтын хүрээлэн” ХХК-ийг 6.481,1 сая төгрөгийн дүрмийн сантайгаар Улаанбаатар хотод байгуулахыг зөвшөөрсөн байна.

Монгол-Японы хамтарсан хөрөнгө оруулалттай “Үндэсний Соёл Амралтын Хүрээлэн” ХХК-ийг үүсгэн байгуулах гэрээнд “хамтарсан компанийн дүрмийн сан нь оролцогч талуудын оруулсан хувь хөрөнгөөс бүрдэнэ” гээд “Компанийн өөрийн хөрөнгө буюу дүрмийн сан нь 6.48 тэрбум төгрөгийн үл хөдлөх болон хөдлөх хөрөнгө байхаар, компани нь нийт хөрөнгийн хэмжээгээр нэг бүр нь 1000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй **6.484.100** /зургаан сая дөрвөн зуун наян дөрвөн мянга нэг зуун/ ширхэг энгийн хувьцаа байхаар” баталж, хувь нийлүүлэгчид дараах байдлаар хувьцааг эзэмшихээр заасан байна. Үүнд:

“Иточу” корпорац **4.796.014** ширхэг буюу дүрмийн сангийн **74 %**

Улаанбаатар хот **1.685.086** ширхэг буюу дүрмийн сангийн **26 %** гэжээ.

### **Хувьцаа эзэмшигчдийн гэрээнд орсон өөрчлөлтүүд**

“Иточу” корпорацын зүгээс нийт 35 га газарт соёл амралтын хүрээлэн байгуулахаар зураг төсөл хийж гэрээ байгуулсан боловч тухайн газрын зарим

талбайг бусад байгууллагад эзэмшүүлсэн байсан тул газрын хэмжээ багасаж, 31.4 га болсон гэсэн үндэслэлээр 2008 оны 9 дүгээр сарын 10-ны өдөр “Үндэсний соёл амралтын хүрээлэн” ХХК-ийн өөрийн эзэмшлийн 74%-ийг Монгол Улсын хуулийн этгээд болох “Ито Инвест” ХХК-д бэлэглэлийн гэрээгээр шилжүүлж, Гадаадын Хөрөнгө Оруулалт, Гадаад Худалдааны Агентлаг болон Улсын Бүртгэлийн газарт албан ёсоор бүртгүүлсэн байна.

Хамтарсан компанийн үр өгөөж, нийслэлээс оруулсан хувь хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор Нийслэлийн Өмчийн Харилцааны газраас Ажлын хэсэг байгуулан, судалгаа шинжилгээ хийсэн бөгөөд тус компанийд эзэмшүүлсэн газрын хэмжээгээр давуу эрхийн хувьцаа эзэмшиж, ногдол ашиг хуваарилуулах саналыг боловсруулан хүргүүлж, зөвшилцөлд хүрсэн.

Улмаар компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 2013 оны 1-р тэмдэглэл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 118 дугаар тогтоолоор “Хувьцаа эзэмшигчдийн гэрээ”-нд оруулах нэмэлт өөрчлөлтийг баталгаажуулсан. Үүнд:

“А” тал буюу нийслэлээс тавьсан саналын дагуу газрыг хөрөнгө оруулалт гэж тооцон тухайн үеийн мөрдөгдөж байсан Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2010 оны 206 дугаар тушаалыг үндэслэн /газар=314793м<sup>2</sup>\*44,000 төг /жишиг үнэ/\*0,36 итгэлцүүр /УБхотын 1-р бүс/ = 4,986,321,000 төгрөгөөр үнэлэн давуу эрхийн хувьцаа болгон нийт 1,68 тэрбум төгрөгийн 1,68 сая ширхэг энгийн хувьцаа, 4,98 тэрбум төгрөгийн буюу 4,98 сая ширхэг давуу эрхийн хувьцааг нэмж, нийт 6,67 тэрбум төгрөгийн буюу 6,67 сая ширхэг хувьцаатай болгон “А” талд эзэмшүүлнэ.

“А” болон “Б” талын хувь эзэмшлийг тэнцүү хадгалах үүднээс 14,19 тэрбум төгрөгийг “Б” талын хийсэн хөрөнгө оруулалтаас “Үндэсний Соёл Амралтын Хүрээлэн” ХХК-ийн дүрмийн санд нэмж оруулан “Б” талын дүрмийн сангийн хэмжээг нийт 18,9 тэрбум төгрөгийн 18,98 сая ширхэг хувьцаа болгон “Б” талд эзэмшүүлнэ.

“А” талын давуу эрхийн хувьцаа болох 4,98 тэрбум төгрөгийн хувьцаанд хамтарсан компани ашигтай эсвэл алдагдалтай ажилласан болохоос үл хамаарч, жил бүр **698.0 сая төгрөгийг ногдол ашиг** хэлбэрээр хуваарилахаар тохиролцон гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан.

Улаанбаатар хотын дэд бүтцийг хөгжүүлэх, авто замын түгжрэлийг бууруулах зорилтын хүрээнд БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Замын цагдаагийн гүүрэн гарц барих” төслийг 2016 оноос хэрэгжүүлж эхэлсэнтэй холбогдуулан хамтарсан компанийн эзэмшлийн газраас хэсэгчлэн авах зайлшгүй шаардлага бий болсон.

Иймд Нийслэлийн Засаг даргын нэгдүгээр орлогчоор ахлуулсан Ажлын хэсэг “Ито-Инвест” ХХК-тай уулзалт зохион байгуулж, зөвшилцсөнөөр компанийн эзэмшил газрыг гүүрэн гарц барих төсөлд ашиглуулахаар, гүүрэн гарц барьж дуусах хүртэл хугацаанд компанийг ногдол ашгаас чөлөөлөхөөр тохиролцсон. Дээрх гэрээний нэмэлт өөрчлөлтийг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 27 дугаар тогтоолоор баталгаажуулсан. Үүнд:

Гэрээний 1.3 дахь хэсэгт “Замын цагдаагийн газрын ойролцоо гүүрэн гарц барих төслийн ажлыг дуусгаж, ашиглалтад оруулах хүртэл ногдол ашгаас чөлөөлнө” гэж нэмж тусгах

Гэрээний 1.10 дахь хэсэгт гүүрэн гарц барих төслийг хэрэгжүүлж, нөлөөлөлд өртсөн газрыг зохих журмын дагуу чөлөөлөхөд хамтран ажиллаж, уг үйл ажиллагаанд ямар нэгэн саад учруулахгүй болно гэсэн заалтуудыг нэмж оруулан баталгаажуулсан.

Дээрх тогтоолын дагуу 2018 оны 05 дугаар сарын 02-ны өдөр “Үндэсний Соёл Амралтын Хүрээлэн” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулан хамтарсан компанийн гэрээнд холбогдох өөрчлөлтийг оруулан баталгаажуулсан байна.

## **2. Үндэсний соёл амралтын хүрээлэнгийн орчимд газар эзэмшигч иргэн, аж ахуйн нэгж байгууллагын газар ашиглалтын талаар**

Ажлын хэсгээс судлан үзэхэд “Үндэсний соёл амралтын хүрээлэн” ХХК-ийн эзэмшиж буй газар Монгол Улсын Их Хурлын 2013 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичиг”-т **хотын болон дүүргийн чанартай соёл амралт, зугаалгын парк, цэцэрлэгт талбай, ногоон байгууламжаар** тусгагдсан байна. Мөн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2008 оны 18 дугаар тогтоолоор батлагдсан “Зайсан толгой орчмын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө”-нд Соёл амралтын цогцолбор барилгууд, парк, цэцэрлэгт талбай, ногоон байгууламжаар тусгагдсан байна.

“Үндэсний соёл амралтын хүрээлэн” ХХК-ийн эзэмшиж буй газрын ойр орчим тухайн компанийг оролцуулаад нийт 8 этгээд газар эзэмшиж байна. Үүнд:

### **1.“Үндэсний соёл амралтын хүрээлэн” ХХК**

Нийслэлийн Засаг даргын 1997 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/03 дугаар захирамжаар 35 га газрыг амралт зугаалгын цогцолборын зориулалтаар “Монголын үндэсний соёл амралтын хүрээлэн”-д 4 жилийн хугацаатай ашиглуулахаар шийдвэрлэсэн байна.

Нийслэлийн Засаг даргын 2005 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 263 дугаар захирамжаар 358,714 м.кв газрыг амралт зугаалгын цогцолборын зориулалтаар “Монголын үндэсний соёл амралтын хүрээлэн” НӨҮГ-т 15 жилийн хугацаатай эзэмшүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Нийслэлийн Засаг даргын 2007 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 577 дугаар захирамжаар 324,965 м.кв газрыг амралт зугаалгын цогцолборын зориулалтаар “Монголын үндэсний соёл амралтын хүрээлэн” ХХК-д 15 жилийн хугацаатай эзэмшүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Нийслэлийн Засаг даргын 2009 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 21 дүгээр захирамжаар 324,965 м.кв газрыг амралт зугаалгын газрын зориулалтаар “Монголын үндэсний соёл амралтын хүрээлэн” ХХК-д 5 жилийн хугацаатай ашиглуулахаар шийдвэрлэсэн байна.

Нийслэлийн Засаг даргын 2010 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 582 дугаар захирамжаар 324,965 м.кв газрыг 325,793 м.кв болгон талбайн хэмжээг нэмэгдүүлж амралт зугаалгын газрын зориулалтаар “Монголын үндэсний соёл амралтын хүрээлэн” ХХК-д 5 жилийн хугацаатай ашиглуулахаар шийдвэрлэсэн байна.

Нийслэлийн Засаг даргын 2011 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 198 дугаар захирамжаар 314,793 м.кв газрыг амралт зугаалгын газрын зориулалтаар “Монголын үндэсний соёл амралтын хүрээлэн” ХХК-д 5 жилийн хугацаатай эзэмшүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Нийслэлийн Засаг даргын 2015 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн А/902 дугаар захирамжаар 314,793 м.кв газрыг 314,265 м.кв болгон талбайн хэмжээг багасгаж амралт, зугаалгын цогцолборын зориулалтаар “Монголын үндэсний соёл амралтын хүрээлэн” ХХК-д 60 жилийн хугацаатай эзэмшүүлж шийдвэрлэсэн байна.

Газрын төлбөрт 2009-2020 оны байдлаар нийт 1,348,600,160 төгрөг төлсөн байна.

## 2.“Шангрила Улаанбаатар хотел” ХХК

Нийслэлийн Засаг даргын 1998 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн А/115 дугаар захирамжаар зочид буудал, конторын зориулалтаар 4900 м.кв газрыг “Монтоно” ХХК-д 3 жилийн хугацаатай ашиглуулахаар шийдвэрлэсэн.

Нийслэлийн Засаг даргын 2002 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 35 дугаар захирамжаар конторын зориулалтаар 0,49 га газрыг “Монтоно” ХХК-д 4 жилийн хугацаатай ашиглуулахаар шийдвэрлэсэн.

Нийслэлийн Засаг даргын 2006 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн 434 дүгээр захирамжаар контор, үйлчилгээ, зочид буудлын зориулалтаар 4900 м.кв газрыг “М Си Эс Хотел” ХХК-д 5 жилийн хугацаатай эзэмшүүлэхээр шийдвэрлэсэн. /Монгол Улсын Дээд захиргааны хэргийн шүүх хуралдааны 55 дугаар тогтоолоор “Монтоно” ХХК-ийн газар эзэмших эрхийг сэргээж шийдвэрлэсэн./

Нийслэлийн Засаг даргын 2007 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 06 дугаар захирамжаар контор, үйлчилгээ, зочид буудлын зориулалтаар 30000 м.кв газрыг “М Си Эс Хотел” ХХК-д 15 жилийн хугацаатай эзэмшүүлэхээр шийдвэрлэсэн.

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2007 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн 156 дугаар тогтоолоор контор, үйлчилгээ, зочид

буудлын зориулалтаар 30000 м.кв газрыг “Шангрила Улаанбаатар Хотел” ХХК-д 5 жилийн хугацаатай ашиглуулахаар шийдвэрлэсэн.

Нийслэлийн Засаг даргын 2007 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 473 дугаар захирамжаар үйлчилгээ, зочид буудлын зориулалтаар 30000 м.кв газрыг “Шангрила Улаанбаатар Хотел” ХХК-д 60 жилийн хугацаатай ашиглуулахаар шийдвэрлэсэн.

Нийслэлийн Засаг даргын 2015 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн А/985 дугаар захирамжаар үйлчилгээ, зочид буудал, оффис, орон сууцны зориулалтаар 30000 м.кв газрыг Шангрила Улаанбаатар Хотел ХХК-д 5 жилийн хугацаатай ашиглуулахаар шийдвэрлэсэн.

Газрын төлбөрт 2015-2021 оны байдлаар нийт 167,969,280 төгрөг төлсөн байна.

### **3.“Сөүл” ХХК**

Нийслэлийн Засаг даргын 2001 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 519 дүгээр захирамжаар хүүхэд залуучуудын спорт цогцолборын барилгын зориулалтаар 0,17 га газрыг 2 жилийн хугацаатай ашиглуулахаар шийдвэрлэсэн.

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2003 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 159 дугаар тогтоолоор 3200 м.кв газрыг үйлчилгээний зориулалтаар 5 жилийн хугацаатай ашиглуулахаар шийдвэрлэсэн.

Нийслэлийн Засаг даргын 2008 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 181 дүгээр захирамжаар үйлчилгээний зориулалтаар 3200 м.кв газрыг иргэн Д.Өнөрболорт 15 жилийн хугацаатай эзэмшүүлэхээр шийдвэрлэсэн.

Нийслэлийн Засаг даргын 2010 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 582 дугаар захирамжаар үйлчилгээний зориулалтаар 2217 м.кв газрыг иргэн Д.Өнөрболорт 15 жилийн хугацаатай эзэмшүүлэхээр шийдвэрлэсэн.

Газрын төлбөрт 2010-2020 оны байдлаар нийт 15,358,805 төгрөг төлсөн байна.

### **4.“Мон уран” ХХК**

Нийслэлийн Засаг даргын 2011 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 198 дугаар захирамжаар конторын зориулалтаар 11000 м.кв газрыг 5 жилийн хугацаатай ашиглуулахаар шийдвэрлэсэн.

Нийслэлийн Засаг даргын 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн А/488 дугаар захирамжаар конторын зориулалтаар 11000 м.кв газрыг 15 жилийн хугацаатай эзэмшүүлэхээр шийдвэрлэсэн.

Газрын төлбөрт 2017-2021 оны байдлаар нийт 49,974,510 төгрөг төлсөн байна.

## **5.“Төгс эрдэм сан” НҮТББ**

Нийслэлийн Засаг даргын 2010 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 420 дугаар захирамжаар 0.033 га газрыг “Барилга хот байгуулалт, төлөвлөлтийн газар” болон “Төгс эрдэм сан” ТББ-д 5 жилийн хугацаатай эзэмшүүлэхээр шийдвэрлэсэн.

Нийслэлийн Засаг даргын 2014 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн А/388 дугаар захирамжаар сургалтын зориулалтаар 369 м.кв газрыг “Төгс эрдэм сан” ТББ-д 5 жилийн хугацаатай эзэмшүүлэхээр шийдвэрлэсэн.

Нийслэлийн Засаг даргын 2015 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/54 дүгээр захирамжаар сургалт, үйлчилгээний зориулалтаар 601 м.кв газрыг “Төгс эрдэм сан” ТББ-д 5 жилийн хугацаатай эзэмшүүлэхээр шийдвэрлэсэн.

Дуудлага худалдааны анхны үнэ болох 18,780,960 төгрөгийг төлсөн байна. Газрын төлбөрт 2016-2021 оны байдлаар нийт 2,602,340 төгрөг төлсөн байна.

## **6.Монголын Хүүхдийн ордон**

Нийслэлийн Засаг даргын 1997 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/211 дүгээр захирамжаар сургалт, боловсролын үйл ажиллагаа явуулах зориулалтаар 0,88 га газрыг 4 жилийн хугацаатай ашиглуулахаар шийдвэрлэсэн.

Нийслэлийн Засаг даргын **2008** оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 296 дугаар захирамжаар сургалт, боловсрол, соёл, хүмүүжлийн зориулалтаар 8875 м.кв газрыг 15 жилийн хугацаатай эзэмшүүлэхээр шийдвэрлэсэн.

Газрын төлбөрт 2009-2021 оны байдлаар нийт 11,604,720 төгрөг төлсөн байна.

## **7.“Хайртохой” ХХК**

Нийслэлийн Засаг даргын 2002 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 405 дугаар захирамжаар үйлчилгээний зориулалтаар 270 м.кв газрыг 3 жилийн хугацаатай ашиглуулахаар шийдвэрлэсэн.

Нийслэлийн Засаг даргын 2005 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн 555 дугаар захирамжаар үйлчилгээний зориулалтаар 270 м.кв газрыг 15 жилийн хугацаатай эзэмшүүлэхээр шийдвэрлэсэн.

Нийслэлийн Засаг даргын 2009 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 303 дугаар захирамжаар дугаар захирамжаар сургалтын зориулалтаар 1592 м.кв газрыг 15 жилийн хугацаатай эзэмшүүлэхээр шийдвэрлэсэн.

Газрын төлбөрт 2009-2021 оны байдлаар нийт 10,746,960 төгрөг төлсөн байна.

## **8.“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК**

Нийслэлийн Засаг даргын 2014 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн А/76 дугаар захирамжаар 0.089 га газрыг 15 жилийн хугацаатай эзэмшүүлэхээр шийдвэрлэсэн.

Нийслэлийн Засаг даргын 2019 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн А/593 дугаар захирамжаар 890 м.кв газрыг 15 жилийн хугацаатай эзэмшүүлэхээр шийдвэрлэсэн.

Газрын төлбөрт 2019-2021 оны байдлаар нийт 638,288 төгрөг төлсөн байна.

### **АЖЛЫН ХЭСГИЙН ДҮГНЭЛТ:**

1. “Ито-Инвест” ХХК-тай байгуулсан хувьцаа эзэмшигчдийн гэрээг дүгнэх ажлын зохион байгуулж, “Үндэсний соёл амралтын хүрээлэн” ХХК-ийн хөрөнгө оруулалт, зардлын хэмжээнд аудитын байгууллагын санал, дүгнэлт гаргуулж, цаашид баримтлах бодлого тодорхойлох нь зүйтэй талаар ажлын хэсгээс гаргасан саналын хүрээнд 2022 оны 02 дугаар сарын 21-ний өдөр Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид болон Нийслэлийн Дотоод Аудитын албанд аудит хийлгэх тухай халбан бичиг хүргүүлсний дагуу тус байгууллагаас аудитын хяналт шалгалтыг хийж эхлээд байна. Цаашид аудитын байгууллагын дүгнэлтийг үндэслэн тус байршилд өмнө газрын эрх олгоходо албан тушаалын байдлаа урвуулан ашигласан эсэхийг тодруулахаар хуулийн байгууллагад хандах.

2. ”Үндэсний соёл амралтын хүрээлэн” ХХК-ийн талаар нийслэлээс баримтлах бодлого, чиглэлийг тодорхойлж, шаардлагатай мэдээ, материалыг бэлтгэж нийтийн сонголтыг зохион байгуулах.

3. ”Үндэсний соёл амралтын хүрээлэн” ХХК-ийн менежментийн багт нийслэлийн төлөөллийг оруулж ажиллуулах, нийслэлийг төлөөлж буй төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тоог нэмэгдүүлж, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын төлөөллийг оруулах замаар компанийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах.

4. ”Үндэсний соёл амралтын хүрээлэн” ХХК-с нийслэлийн төсөвт төвлөрүүлж, ногдол ашиг өгсөн болон ногдол ашиг өгөхийг зогсоосон нь компанийн тухай болон бусад хууль тогтоомжийг зөрчсөн эсэхийг тогтоох.

5. Хувьцаа эзэмшигчийн хувьд “Үндэсний соёл амралтын хүрээлэн” ХХК-ийн талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх. Үүнд:

5.1 “Үндэсний соёл амралтын хүрээлэн” ХХК-ийн нийслэлийн эзэмшлийн хувьцааг нэмэгдүүлэх талаар судлах, хувьцаа эзэмшигч “Ито-Инвест” ХХК-тай зөвшилцэх.

5.2 “Үндэсний соёл амралтын хүрээлэн” ХХК-ийн хэрэгжүүлэхээр төлөвлөж буй “Villa” төслийн эдийн засгийн болон нийгмийн үр ашгийг дүгнэж, хувьцаа эзэмшигчийн хувиар тус төслийг хэрэгжүүлэхийг дэмжих эсэх талаар шийдвэр гаргах.

5.3 “Улаанбаатр хотын өрөнхий архитекторын баталсан 2018 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн МЗХ-2018/27-14 дугаартай архитектур төлөвлөлтийн даалгавар, гурван давхар хүртэл батлагдсан олон зориулалтын талбайтай үйлчилгээ, соёл, амралтын төвийн зориулалтаар батлагдсан эх загвар зургийг яаралтай хүчингүй болгож, зөвхөн ногоон байгууламж, тохижилтын чиглэлээр архитектур төлөвлөлтийн даалгавар, эх загвар зураг батлах болон “Үндэсний соёл амралтын хүрээлэн” ХХК-ийн ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэнгийн төслийг дараагийн шатанд нэн яаралтай эхлүүлэх зэрэг асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэх.

6. Үндэсний соёл амралтын хүрээлэнгийн эзэмшил 31.4 га газрыг цаашид зөвхөн хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, амралт, зугаалга, цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийн зориулалтаар ашиглаж, талбайн хэмжээ болон зориулалтад өөрчлөлт оруулахгүй, бусдад шилжүүлэхгүй байх, газар эзэмших гэрээнд заасан зориулалтын дагуу эзэмшиж, ашиглалт хамгаалалтад хяналт тавьж, эргэлтийн цэг тэмдэгтийг тогтоож, газрын кадастрын мэдээллийн санд бүртгэх арга хэмжээ авч ажиллах, тухайн газарт шинээр газар эзэмшүүлэх захирамж гаргахыг хориглох чиглэлээр Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолын төсөл өргөн барих.

Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг ажлын хэсгийн гишүүдийн 100 хувийн саналаар дэмжсэн болно.

АЖЛЫН ХЭСГИЙН АХЛАГЧ

  
Б.МЯГМАР

ГИШҮҮД:

  
Д.ГАНТУЛГА

  
Д.ЭНХТУЯА

  
М.ХАЛИУНБАТ

  
Н.БАТСҮМБЭРЭЛ

  
П.НАРАНБАЯР

  
Н.БАЯРЧИМЭГ

  
Ш.ҮНЭНБАТ

  
Ц.ТУЛГА

  
Г.БАТЗОРИГ



М.БАЯРАА



А.АНХБАЯР



Б.МӨНГӨНШАГАЙ

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



П.ДАМБАЧҮЛТЭМ

ТӨСӨЛ

НИЙСЛЭЛИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2022 оны ... сарын ...-ны өдөр

Дугаар

Улаанбаатар хот

“Үндэсний соёл амралтын хүрээлэн” ХХК-ийн газар эзэмшилт, ашиглалт, түүний зориулалтын талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.17 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.1 дэх заалт, Нийтийн сонсголын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалт, Улсын Их Хурлын 2013 оны “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичгийг батлах тухай” 23 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч /Д.Сумъяабазар/-д дараах чиглэлээр үүрэг болгосугай. Үүнд:

1.1 Үндэсний соёл амралтын хүрээлэнгийн эзэмшил 31.4 га газрыг цаашид зөвхөн хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, амралт, зугаалга, цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийн зориулалтаар ашиглаж, талбайн хэмжээ болон зориулалтад өөрчлөлт оруулахгүй, бусдад шилжүүлэхгүй байх;

1.2 Тус газрыг газар эзэмших гэрээнд заасан зориулалтын дагуу эзэмшиж, ашиглалт хамгаалалтад хяналт тавьж, эргэлтийн цэг тэмдэгтийг тогтоон газрын кадастрын мэдээллийн санд бүртгэх;

1.3 Шаардлагатай материалыг бүрдүүлэн нийтийн сонсгол зохион байгуулах;

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга /Б.Батбямба/-д даалгасугай.

ДАРГА

Ж.БАТБАЯСГАЛАН